

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 94209011 Цахим хаяг: nurlans@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
4.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ К.САЛТАНАТ ТАНАА

2022.02.25 № 188
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Dugnelt-TA

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Dugnelt-TA

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>158035298.84</u>	<u>112346096.94</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	146437321.84	112346096.94
354	Хангамжийн материал	146437321.84	112346096.94
35410	Бичиг хэргийн материал	379900.00	0.00
35420	Аж ахуйн материал	43321770.00	51495225.00
35440	Түлш, шатах тослох материал	10725000.75	369022.35
35460	Хүнсний материал	61545999.09	30041197.59
35470	Бусад хангамжийн материал	30464652.00	30440652.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3057393375.08</u>	<u>2772461541.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3057393375.08	2772461541.44
392	Биет хөрөнгө	3033983375.08	2749051541.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	3008857864.48	3038857864.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-168363282.46	-463322609.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68213500.00	68213500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18213500.00	-24463499.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121123004.00	130217854.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91853988.14	-99788902.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137599202.00	139399202.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51187621.55	-69457676.63
39217	Ном	27808196.75	29395809.15
393	Биет бус хөрөнгө	23410000.00	23410000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23410000.00	23410000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3215428673.92</u>	<u>2884807638.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>22176530.00</u>	<u>11199000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22176530.00	11199000.00
413	Өглөг	22176530.00	11199000.00
4136	Бусад өглөг	22176530.00	11199000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	22018930.00	11199000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	157600.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3193252143.92</u>	<u>2873608638.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3193252143.92	2873608638.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	299861904.00	299861904.00
51101	Өмч: - төрийн	299861904.00	299861904.00
512	Хуримтлагдсан үр дүн	2418032160.30	2098388654.76
51210	Өмнөх үеийн үр дүн	2418032160.30	2418032160.30
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-319643505.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	475358079.62	475358079.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ	<u>3215428673.92</u>	<u>2884807638.38</u>

	ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		
--	---------------------------	--	--

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,450,584,445.00	1,283,541,824.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,550,120.00	345,594.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,550,120.00	345,594.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,550,120.00	345,594.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,550,120.00	345,594.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,443,034,325.00	1,283,196,230.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,393,298,302.00	1,225,659,812.40
131005	Хөрөнгийн санхүүжилт	209,710,502.00	31,137,612.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,183,587,800.00	1,194,522,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	4,937,198.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	4,937,198.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,921,100.00	48,525,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,921,100.00	48,525,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,814,923.00	4,074,220.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,814,923.00	4,074,220.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,283,478,606.19	1,603,185,329.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,283,478,606.19	1,603,185,329.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,261,412,733.19	1,571,109,655.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	932,457,023.00	969,909,340.70
210101	Үндсэн цалин	776,668,031.00	853,637,223.70
210104	Урамшуулал	92,259,992.00	52,847,743.00
210105	Гэрээт ажлын хөлс	63,529,000.00	63,424,374.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,936,900.00	125,887,174.00
210201	Тэтгэврийн даатгал	87,918,600.00	89,421,574.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,254,600.00	9,116,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,403,600.00	7,293,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,851,000.00	1,823,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,509,100.00	18,232,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,912,349.25	50,524,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,620,400.00	3,382,700.00
210302	Түлш, халаалт	45,109,949.25	47,142,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,182,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	29,109,690.00	14,526,205.40
210401	Бичиг хэрэг	625,500.00	1,644,298.00

**Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	1,579,460.00	2,521,118.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,138,000.00	1,354,000.00
210404	Ном, хэвлэл	105,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,831,688.00	9,006,789.00
210408	Бараа материал акталсны зардал	11,830,042.00	-
2105	Нормативт зардал	53,463,560.40	79,176,970.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	372,600.00	242,000.00
210502	Хоол, хүнс	53,090,960.40	78,934,970.50
2107	Томилолт, зочны зардал	945,600.00	154,200.00
210702	Дотоод албан томилолт	945,600.00	154,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.00	954,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	454,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,987,610.54	329,976,615.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,552,620.00	2,562,319.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,434,990.54	327,414,296.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,065,873.00	32,075,674.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,132,723.00	28,691,362.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,814,923.00	4,074,220.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,317,800.00	24,617,142.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,933,150.00	3,384,312.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,933,150.00	3,384,312.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>167,105,838.81</u>	<u>(319,643,505.54)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>167,105,838.81</u>	<u>(319,643,505.54)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	299,861,904.00	479,742,690.62	1,407,581,244.46	2,187,185,839.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			4,384,611.00	4,384,611.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	299,861,904.00	479,742,690.62	1,411,965,855.46	2,191,570,450.08
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний		-4,384,611.00		-4,384,611.00

	бууралт				
C07	Тайлант үеийн үр дүн			1,006,066,304.84	1,006,066,304.84
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	475,358,079.62	2,418,032,160.30	3,193,252,143.92
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	475,358,079.62	2,418,032,160.30	3,193,252,143.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	299,861,904.00	475,358,079.62	2,418,032,160.30	3,193,252,143.92
D08	Тайлант үеийн үр дүн			-319,643,505.54	-319,643,505.54
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,861,904.00	475,358,079.62	2,098,388,654.76	2,873,608,638.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1233323823.00	1252058618.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1233323823.00	1252058618.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1183587800.00	1194522200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1183587800.00	1194522200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5000000.00	4937198.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5000000.00	4937198.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37921100.00	48525000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37921100.00	48525000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6814923.00	4074220.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6814923.00	4074220.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1229324823.00	1240713768.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1229324823.00	1240713768.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1205711450.00	1200935035.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	944055000.00	958311363.70
210101	Үндсэн цалин	788266008.00	842039246.70
210104	Урамшуулал	92259992.00	52847743.00
210105	Гэрээт ажлын хөлс	63529000.00	63424374.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124936900.00	125887174.00
210201	Тэтгэврийн даатгал	87918600.00	89421574.00

**Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210202	Тэтгэмжийн даатгал	9254600.00	9116300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7403600.00	7293000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1851000.00	1823600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18509100.00	18232700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37921100.00	47775000.00
210301	Гэрэл, цахилгаан	3713100.00	5620000.00
210302	Түлш, халаалт	33126000.00	41155000.00
210303	Цэвэр, бохир ус	1082000.00	1000000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6777650.00	10701798.00
210401	Бичиг хэрэг	866100.00	599398.00
210402	Тээвэр, шатахуун	1259250.00	2023000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1138000.00	1354000.00
210404	Ном, хэвлэл	675100.00	405000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		400000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2839200.00	5920400.00
2105	Нормативт зардал	84066900.00	43775810.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	422700.00	983800.00
210502	Хоол, хүнс	78873000.00	39717110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4771200.00	3074900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	750000.00
210604	Урсгал засвар	0.00	750000.00
2107	Томилолт, зочны зардал	1574700.00	412740.00
210702	Дотоод албан томилолт	1574700.00	412740.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	810000.00	2753400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210000.00	2253400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	500000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5569200.00	10567750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2000000.00	4300000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3569200.00	6267750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23613373.00	39778732.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	20680223.00	36394420.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6814923.00	4074220.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13865300.00	32320200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2933150.00	3384312.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2933150.00	3384312.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3999000.00</u>	<u>11344850.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3999000.00	11344850.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3999000.00	11344850.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3999000.00	11344850.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3999000.00	11344850.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3999000.00</u>	<u>-11344850.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны	
		Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1243047200.00	1239662887.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1243047200.00	1239662887.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1210727000.00	1207342687.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		958696500.00	958311363.70
210101	Үндсэн цалин		842227500.00	842039246.70
210104	Урамшуулал		52940000.00	52847743.00
210105	Гэрээт ажлын хөлс		63529000.00	63424374.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		128885000.00	125887174.00
210201	Тэтгэврийн даатгал		90537200.00	89421574.00
210202	Тэтгэмжийн даатгал		9586900.00	9116300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		7669500.00	7293000.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1917400.00	1823600.00
210205	Эрүүл мэндийн даатгал		19174000.00	18232700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		47775000.00	47775000.00
210301	Гэрэл, цахилгаан		5620000.00	5620000.00
210302	Түлш, халаалт		41155000.00	41155000.00
210303	Цэвэр, бохир ус		1000000.00	1000000.00
210304	Байрны түрээс			
2104	Хангамж, бараа материалын зардал		13227100.00	13227100.00
210401	Бичиг хэрэг		362200.00	362200.00
210402	Тээвэр, шатахуун		2023000.00	2023000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1354000.00	1354000.00
210404	Ном, хэвлэл		517500.00	517500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		8970400.00	8970400.00
2105	Норматив зардал		43775900.00	43775810.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		983800.00	983800.00
210502	Хоол, хүнс		39717200.00	39717110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		3074900.00	3074900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		750000.00	750000.00
210604	Урсгал засвар		750000.00	750000.00
2107	Томилолт, зочны зардал		414000.00	412740.00
210702	Дотоод албан томилолт		414000.00	412740.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2753400.00	2753400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2253400.00	2253400.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		500000.00	500000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		14450100.00	14450100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		14450100.00	14450100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		32320200.00	32320200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		32320200.00	32320200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		32320200.00	32320200.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1243047200.00	1239662887.70
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		1194522200.00	1191137887.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		1194522200.00	1191137887.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		48525000.00	48525000.00
132001	Орон нутгийн төсвөөс		48525000.00	48525000.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		50.0	50.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		25.00	25.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		22.00	22.00
650010	Гэрээт ажилтан		3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4937198.00	4937198.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4937198.00	4937198.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4937198.00	4937198.00
2104	Хангамж, бараа материалын зардал	637198.00	637198.00
210401	Бичиг хэрэг	237198.00	237198.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4300000.00	4300000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4300000.00	4300000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4937198.00	4937198.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4937198.00	4937198.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4937198.00	4937198.00

Төгрөгөөр

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь хүүхдийн эрхийг дээдэлсэн, сурагчдад стандартаар тогтоосон бага боловсрол олгох, эзэмшүүлэх, сургалтын хөтөлбөрийн агуулгыг баяжуулах, багшийг чадавхжуулах замаар сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, хүүхэд бүрийг хөгжүүлэх, хүүхдийг төлөвшүүлэх, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүд бэлтгэхэд оршино..

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус албанаас сургуулийн 2021 оны үйл ажиллагаанд баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1283.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 330.6 сая төгрөгөөр буюу 10.3 хувиар буурсан байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	11,598.0	0.00	-11,598.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	146,437.3	112,346.0	-34,091.2
Үндсэн хөрөнгө	3,057,393.3	2,772,461.5	-284,931.8
Нийт хөрөнгө	3,215,428.6	2,884,807.6	-330,621.0
Өр төлбөр	22,176.53	11,199.0	-10,977.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,193,252.1	2,873,608.6	-319,643.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,215,428.6	2,884,807.6	-330,621.0

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлагын данс оны эцэст үлдэгдэлгүй 11.6 сая төгрөгөөр буурсан нь оны эхний 11.6 сая төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой. Энэ нь өмнөх оны аудитаар цалингийн зардлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын шимтгэл, татварт

илүү шилжүүлж шинээр үүсгэсэн 11.6 сая төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 112.3 сая төгрөг болж 34.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 123.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 157.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Аж ахуйн материал 51.5 сая, Хүнсний материал 30.0 сая, Бусад хангамжийн материал 30.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь бараа материалын нийт үлдэгдлийн 99.6 хувийг эзэлж байна.

Хүнсний материалын дансанд оны эхэнд 61.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 39.7 сая төгрөгийн хүнс худалдан авч, 71.3 сая төгрөгийн материалыг зарцуулж 30.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь цар тахлын хязгаарлалтай холбоотой сургуулийн үйл ажиллагаа зогсоход чанар байдлаа алдаж муудах эрсдэлтэй байна. Өмнөх оны аудитаар хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлж 22.2 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,772.4 сая төгрөг болж 284.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 11.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 321.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэгүй хүлээн авч, үндсэн хөрөнгөд 327.4 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр оны эцэст 11.1 сая төгрөг болж 10.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Оны эхний 11.6 сая төгрөгийн авлагыг хоорондын тооцоогоор барагдуулж, оны эцэст 3.4 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн зэргээс дүгнэлт хийж үзэхэд оны эцсийн өглөгийг бүрэн барагдуулж өглөггүй гарах боломж байжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,873.3 сая төгрөг болж 319.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 319.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,283.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 167.0 сая төгрөгөөр буюу 11.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан нь хөрөнгийн санхүүжилт буурсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,603.1 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 319.7 сая төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан цалин, норматив зардал, элэгдлийн зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны анх батлагдсан төсөв 1189.3 сая төгрөг, тодотгосон төсөв 1243.0 сая төгрөг байна.

Тодотголоор анх баталсан төсвийг 54.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд: Цалин хөлс болон НДШ-ийн зардал 14.8 сая, хангамж, бараа материалын зардал 7.6 сая, бараа үйлчилгээний бусад зардал 10.0 сая төгрөгөөр нэмэгдэж, норматив зардал 67.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1243.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1239.0 сая төгрөгийг зарцуулж, 3.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн 77.4 хувийг цалин, 10.1 хувийг НДШ-ийн зардал, 3.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 1.0 хувийг хангамж, бараа материалын зардал, 3.5 хувийг норматив зардал, 0.7 хувийг эд хогшил худалдан авах зардал, томилолт, зочны зардал 0.4 хувь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний зардал 0.3 хувь, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал 2.8 хувь тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд 4.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой мэдээллүүдийг бүрэн толилуулан, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай цалин, НДШ-ийн зардал, тогтмол зардал, хоолны зардал, үдийн цайны зардал, норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардалд нийтдээ 1,166.7 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 35.2 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 3.5 сая төгрөг хэмнэх тооцоо гарч байгаа ба 3.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Харин сургууль нь оны эхний 11.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, татварын авлагыг хоорондын тооцоогоор барагдуулсан боловч 11.2 сая төгрөгийн өглөгтэй гарсан, 11.0 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авч төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах талаар санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-д зааснаар “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож

чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх”-гэж заасныг зөрчиж өндөр тэтгэвэрт гарсан нэг хүний орон тоонд 2021 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс шинээр нэг хүн ажилд авч 2.3 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанхус сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2021 онд нийт 1,239.7 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 114 мэдээллийг хугацаандаа байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах 2 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Тайлан оны аудитаар шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагын хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгийн маягтаар шилэн дансны хэрэгжилтийг шалгаж үзэхэд хэрэгжилт 91.3 хувийн үзүүлэлттэй тул зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансны мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан ба төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулаагүй зэрэг зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Цалингийн зардлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын шимтгэл, татварт илүү шилжүүлж шинээр 11.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн, хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлж 22.2 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн, сургуулийн захирлын тушаалаар 20.1 сая төгрөгийн аж ахуй, хангамжийн материалыг акталж данснаас хассан, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас дээрх хөрөнгийг акталж данснаас хасах талаар ямар нэг шийдвэр гаргуулаагүй зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд шилэн дансны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, авлагыг 11.6 сая төгрөгөөр буруулсан боловч жилийн эцэст 11.2 сая төгрөгийн өглөгтэй гарч албан шаардлагын бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн зарцуулалт, хүнсний бараа материалын худалдан авалт, бүртгэл тооцоо, зарцуулалтыг анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19.6 сая төгрөгийн зөрчил илэрч 13.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 6.1 сая төгрөгийн зөрчил болон шилэн дансны хэрэгжилтэй холбоотой зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 13.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.Үүнд:

1.Сургууль нь оны эхний 11.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, татварын авлагыг хоорондын тооцоогоор барагдуулсан боловч 11.2 сая төгрөгийн өглөгтэй гарч өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, 11.0 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авсан, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-д заасныг зөрчиж өндөр насны тэтгэвэрт гарсан хүний оронд шинээр нэг хүн ажилд авч 2.3 сая төгрөгийн цалингийн зардал гаргаж төсвийн хэмнэлт гаргах талаар санаачилга гаргаж ажиллаагүй, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны хэрэгжилтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 119 мэдээллийг байршуулахаас 114 мэдээллийг хугацаандаа байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, шилэн дансны хэрэгжилт 91.3 хувьтай байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлан онд хангамж, бараа материалын зардалд 1.4 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардад 1.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2.5 сая төгрөг, томилолтын зардал, норматив зардалд 0.2 сая төгрөг, нийт 6.1 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Сургууль нь жилийн эцэст хүнсний материалын дансанд 30.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба энэхүү үлдэгдэл нь чанар байдлаа алдаж муудах эрсдэлтэй хүнсний материал байгааг анхаарах шаардлагатай байна.

3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж сургуулийн хүүхдийн хоол, хүнсний материалыг бодит хэрэгцээнд үндэслэн худалдан авалт хийх, үлдэгдэлд байгаа хүнсний материал чанар байдлаа алдаж муудах, төсвийн хөрөнгө үр ашиггүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Улаанхус сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	2	19.6					1	13.5	1	6.1

/сая төгрөгөөр/